

“Зүүний гайхамшигт Зүү ороох урлал”



Зорилго: БЭЛАС-ийн сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж, авьяасаа хөгжүүлэн ардын уламжлалт уран хатгамлын төрлөөс суралцах

Үйл ажиллагаа:

- Монгол ардын уламжлалт зүү ороох оёдолыг сурах
- Ардын уламжлалт хэрэглээ болох хөөрөгний даалин, хавтага хийж сурахаас гадна орчин цагийн хэрэглээнд нийцүүлэн үзэгний сав, бэлэгний уут болон бусад дурсгалын зүйл хийж сурах
- Хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн тайлан тавих

Зүү ороох оёдол нь манай үндэсний уламжлалт уран хатгамалын дундаас хамгийн нарийн, төвөгтэй оёгддог оёдлын нэг юм. Эрчтэй утсаар 3-5 өнгөөр дагнаас гарган оёдог. 1 зүү 2 нарийн байдаг. Зүү ороох оёдлоор оёх дараалал Ороох утсаа зүүнд сүвлэж, өнгөн дээр гаргаад, зүүнээсээ сугалан сул орхино. Даруулах утастай зүүний үзүүрийг дээш хагас цухуйлгаж ороох утсаар зүүгээ нар зөв тойруулан хээний дагуу ороож оёно.

Зүү ороосон гогцоог эрхий хурууны хумсаар дарж зүүгээ гүйцэд татаж гогцооны нэг талыг дарж оёно.

Зүү ороох оёдлын материал Харандаа, хээний зураг, оёх эдлэлийн хэмжээгээр эсгэсэн материал, наалтын материал, зүү, өнгийн дагнасны утаснууд

Зүү ороох оёдлын зааварчилгаа Оёх материалын ар тал дээр наалт наана. Түүн дээр оёх хээгээ зурж буулгана. Оёх утсаа өнгийн дагнаас гарган сонгож бэлтгэнэ. Эхлээд шулуунаар оёх дадлага хийгээд дараа нь хээгээ оёно.

Уран хатгамал

Хатгамалын төрлүүд -Зүү ороох -Хонин холбоо -Цоолбор хатгамал -Шивүүр хатгамал -Шигүү задгай хатгамал-Зээг даруулан оёх -Захлах оёдол -Нохойн шүд хатгах -Загасан нуруу оёх

Хатгамал бол хүн хувцас урлах болсон цагаас эх үүсвэр нь тавигдсан. Хатгамал, наамал болон бусад чимэглэх урлал манай оронд тасралтгүй хөгжиж байгаа нь ардын гар урлалын санг тасралтгүй баяжуулж ирсэн явдал юм. Уран хатгамал дэвсгэр, өнгө зохицол, хээ зэргээс бүрддэг бөгөөд эд бүгд үндэсний зан заншилтай холбоотой гүн гүнзгий утга агуулгатай байдаг. Хатгамал нь олон төрөл бөгөөд тус бүр өвөрмөц онцлогтой байдаг.Хатгамалын сэдэв хүнтөрөлхтний түүхэн хөгжилтэй холбоотой тэрдагуу өөрчлөгдөн хувирч ирсэн. Хатгамалыг хээ угалзаар чимэглэхээс гадна амьтан, ургамал, ус газарзүй, хүний хөрөг болон бодит амьдрал байдлаас эх авч, нийгмийн амьдралыг уран сайхнаар дүрслэн үзүүлдэг гэж хэлж болно.